



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 4/231

Улаанбаатар хот

Г
Бэлгийн замаар дамжих халдвартын
тусламж, үйлчилгээний талаар авах арга
хэмжээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2016 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 10 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ НЬ.

1. Бэлгийн замаар дамжих халдвартын тусламж, үйлчилгээний талаар авах арга хэмжээг 2016 - 2017 онд эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Энхболд/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн /Б.Цогтбаатар/, Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга нар, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, харьяа байгууллагуудын 2016, 2017 оны үйл ажиллагааг үнэлэхдээ БЗДХ, ХДХВ, ДОХ, төрөлхийн тэмбүүг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнг харгалзаж үнэлэхийг Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

САЙД



С.ЛАМБАА

Эрүүл мэнд спортын сайдын
2016 оны 06 сарын 16 өдрийн
A/031 дугаар тушаалын хавсралт

**БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Үйл ажиллагаа | Хариуцах эзэн | Хугацаа |
|---|---|---------------|----------------|
| 1 | Жирэмсний хяналтыг сайжруулах, жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах тэмбүү, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг бууруулах зорилгоор жирэмсний хяналтын хугацаанд тэмбүүгийн шинжилгээг 3 удаа хийх талаар судалж холбогдох зааварт тусган батлуулах | ЭМБХЗГ | 2016 IV улирал |
| 2 | БЗДХ-аас сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх бүсчилсэн зөвлөгөөн"-ийг зохион байгуулах | Сэлэнгэ аймаг | 2016 - 6 сар |
| | | Ховд аймаг | 2016 - 7 сар |
| | | Дорнод аймаг | 2016 - 8 сар |
| 3 | БЗДХ, ХДХВ, ДОХ-ын асуудлаарх Үндэсний VII чуулган"-ыг зохион байгуулах | ЭМБХЗГ | 2016 IV улирал |
| 4 | БЗДХ, ХДХВ, ДОХ, сурьеэгийн мэргэжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эргэн сэргээж, мэргэжлийн салбар зөвлөлийн ажиллах журмыг батлуулах, үйл ажиллагааныг хяналтавих | ЭМБХЗГ | 2016 IV улирал |
| 5 | Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгүүдэд Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс эмч, лаборант нарыг иргээн орон нутгийн эмч, мэргэжилтнүүдийг ажлын байран дээр нь сургаж дадлагажуулах, тухайн аймаг, дүүргээс эмч, мэргэжилтнүүдийг дээрхи эмнэлэгт туршлага судлуулж сурган, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах | ЭМБХЗГ | 2016 - 2017 |
| 6 | БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааг Үндэсний хэмжээнд зохицуулан зохион байгуулах үүрэг бүхий "Үндэсний хороо"-ны бүрэлдэхүүн, дүрмийн төслийг боловсруулж Засгийн газраар хэлэлцүүлэх | ЭМБХЗГ | 2016 - 7 сар |

| | | | |
|----|---|------------------|-----------------|
| 7 | Аймаг, нийслэлийн хэмжээнд орон нутгийн онцлогт тохирсон БЗДХ, ХДХВ, ДОХ-оос урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах, хязгаарлах чиглэлээр “Эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийн үлгэрчилсэн загвар боловсруулах | ЭМБХЗГ | 2016 - 8 сар |
| 8 | БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авах арга хэмжээний тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулах | ЭМБХЗГ | 2016 III улирал |
| 9 | БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусlamж үйлчилгээний зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах | ХӨСҮТ | 2016-10 сар |
| 10 | БЗДХ-ын тандалтыг сайжруулах зорилгоор аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвийн БЗДХ, ХДХВ, ДОХ-ын кабинетийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналтыг тогтмолжуулж ажиллах | ХӨСҮТ | 2016 - 2017 |
| 11 | Эрүүл мэндийн сайдын 2012 оны “Үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар ХДХВ-ын халдварт илрүүлэх, тандалт хийх тухай” 191 дүгээр тушаалын хэрэгжилтийн тайланг нэгтгэх, тогтмол мэдээлэх | ХӨСҮТ | 2016 - 2017 |
| 12 | БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусlamж, үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг 2017 оны төсөвт тусгах саналыг ирүүлэх | ХӨСҮТ | 2016 - 7 сар |
| 13 | БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалд хамруулах асуудлыг судалж, холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх | ХӨСҮТ | 2016 IV улирал |
| 14 | Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад дутагдалтай байгаа БЗДХ, ХДХВ, ДОХ-ын эмч, халдварт судлаач эмч, лабораторийн эмчийг төрийн сангийн тэтгэлгээр сургах асуудлыг судалж, шийдвэрлэх арга хэмжээ авах | ЭМХТ | 2016 III улирал |
| 15 | БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг мэдээллийн бүх төрлийн сувгийг ашиглан идэвхитэй зохион байгуулах | НЭМ-ийн хүрээлэн | 2016 - 2017 |
| 16 | Эрүүл мэндийн сайдын 2012 оны “Үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар ХДХВ-ын халдварт | Төв эмнэлэг, | 2016 - 2017 |

| | | | |
|----|---|--|----------------|
| | илрүүлэх, тандалт хийх тухай” 191 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангаж, тайланг тухайн жилийн эцэст ХӨСҮТ-д илгээх, эргэн мэдээлэлд дүн шинжилгээ хийдэг байх | тусгай мэргэжлийн төв | |
| 17 | БЗДХ, ХДХВ, ДОХ болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, жирэмсний хяналтын цогц тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ялангуяа өрх, сумын эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, амаржих газар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг идэвхижүүлэх | Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг | 2016 - 2017 |
| 18 | БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, тоног төхөөрөмжийн зардал, хүний нөөцийн шаардлагатай төсвийг тооцон 2017 оны улсын төсвийн төсөлд тусгах | Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг | 2016 - 7 сар |
| 19 | Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5095:2013”-д заасны дагуу БЗДХ, ХДХВ, ДОХ-ын нарийн мэргэжлийн эмч, халдварт судлаач, лабораторийн эмч нарыг бүрэн орон тоогоор нь ажиллуулах асуудлыг зохион байгуулж, хүний нөөцийг сургаж бэлтгэх талаар өөрийн байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэх | Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг | 2016 - 2017 |
| 20 | Харьяа нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон БЗДХ, ХДХВ, ДОХ-оос урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах, хязгаарлах чиглэлээр “Эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлэх | Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг | 2016 IV улирал |
| 21 | Өөрийн орон нутгийн хэмжээнд БЗДХ-ыг илрүүлэх, сэргийлэх чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, эмчилгээ хийх арга хэмжээ авах | Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг | 2016 - 2017 |